

ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ ГАЗАР

Огноо: 2019 оны 10 дугаар сарын 09

**АВТО ЗАМЫН НӨХӨН СЭРГЭЭЛТ ЗАСВАРЫН АЖЛЫН ХУДАЛДАН АВАХ
ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: **Авто замын нөхөн сэргээлт засварын ажил**

Төслийн дугаар: **ОСЧААУГ-АЗ-19/01**

**Улаанбаатар
2019 он**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2019.10.09

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Авто замын нөхөн сэргээлт засварын** ажлыг гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 10 цаг 30 минутаас** өмнө www.tender.gov.mn цахим системд ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 11 цаг 00 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй, эрхгүй эсэх: **Эрхгүй**
Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу.

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар

Утас: 70111722

Цахим хаяг: www.tender.gov.mn

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
 - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
 - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
 - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
 - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
 - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлгэдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
 - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарыт үндэслэнэ.
 - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
 - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарыт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
 - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
 - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 6. Алдааг залруулах**
 - 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:

- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үргүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- | | |
|--|--|
| 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| | 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ.</p> <p>2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулан ирүүлэх/</p> <p>3. Компанийн дэлгэрэнгүй танилцуулга</p> <p>4. Сүүлийн 1 /2018 он/ жилийн санхүүгийн тайлан ирүүлэх</p> <p>5. Ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл: /2018 онд доод тал нэг удаа ижил төстэй ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна.</p> <p>Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар</p> <p>Ажил хүлээлцсэн акт болон протоколын хуулбар</p> <p>6. Татварын тодорхойлолт ирүүлнэ. /Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын www.etch.mta.mn сайтаас авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна.</p> <p>7. “Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлгүй” тухай харилцагч банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ.</p> <p>8. Ажлын тоо хэмжээний, шаардлагын дагуу санал болгосон үнээрээ, хугацаандaa чанартай хийж гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлнэ.</p> <p>9. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт ирүүлэх</p> <p>10. Шүүхийн ерөнхий зөвлөл, шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт ирүүлэх</p> <p>11. Баталгаат хугацаа 1 жил эсхүл түүнээс дээш жил байна. /Баталсан албан бичиг ирүүлнэ/</p> <p>12. ТШӨХ-д заасан материалын аль нэгийг тендерт хавсарган ирүүлээгүй бол тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p> <p>Цахим хаяг: www.tender.gov.mn</p> <p>Огноо: 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр</p> <p>Цаг: 10 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</p>

	<p>Цахим хаяг: www.tender.gov.mn Огноо: 2019 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Цаг: 11 цаг 00 минут</p>
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: багцгүй

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. Байршил	Авто замын нөхөн сэргээлт засварын ажил
2. Ажлын цар хэмжээ	Энэхүү гэрээнд Ажлын тоо хэмжээ гэсэн бүлэгт байгаа ажлуудыг хийж гүйцэтгэнэ
3. Ажлын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлагууд	<ul style="list-style-type: none"> Ажлыг гүйцэтгэж байх явцад технологийн үе шат бүрд гүйцэтгэсэн ажлыг төслийн менежерт үзүүлж байх ба техникийн шаардлага хангасан гэж үзвэл холбогдох газруудад туршилт, шахалтуудыг хийлгэх зөвшөөрлийг авч ил, далд, ажлын акт, гүйцэтгэлийн фото зураг үйлдснээр дараагийн үе шатны ажлыг гүйцэтгэнэ. Ажил гүйцэтгэх явцад талбайд ажиллаж буй ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгааг тогтмол өгч ажиллана. Гэрээнд тусгагдсан бүх ажлыг Монгол улсад мөрдөж буй хууль, тогтоомж, БНБД, стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Засварын ажлыг хийж гүйцэтгэхдээ гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хугацаанд нь ашиглалтанд өгөхөөр ажлын талбайн зохион байгуулалтыг хийх шаардлагатай.

Тав. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ

- Засварын ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртлэх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина.
- Материалын чанарт хяналт тавих
- Ажлын явцад гарах зураг, төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлэх.
- Магадлашгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн менежерийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон, төсөв тооцоо хийж /шаардлагатай бол зураг хийх/ баталгаажуулж санхүүжүүлэх.

Зургаа. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

1. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээ, зургийн дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан, акт үйлдэнэ.
3. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
4. Мөн байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна.
5. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх.
6. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүн хавсаргаж ирүүлнэ. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн, бетон зуурмагийн дээжээс сорилын шоо авч лабораторийн дүгнэлт гаргуулсан байна.
7. Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Дээрх техникийн тодорхойлолтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

АЖЛЫН ТОО ХЭМЖЭЭ

Д/д	Дүүрэг	Хороо	УДДТ	Нөхөн сэргээх талбай		Сэтэлсэн замын байршил	Тайлбар					
				Хэмжих нэгж	Тоо хэмжээ							
ЗҮҮН ТҮГЭЭХ ТӨВ												
2017 он												
1	СБД	6	УДДТ-40	м2	23	53,54-р байрны урд						
2	СБД	6	УДДТ-37	м2	18	45-р байрны үүдэнд авто зогсоол						
3	СБД	6	ХҮТ-5	м2	36	Хүрээ төв, Хорооны хашаан доторх явган хүний зам						
4	СБД	6	УДДТ-42	м2	24	МОНРО-ын хашааны үүдэнд явган хүний зам						
5	БЗД	3	УДДТ-21	м2	12	47-р байрны урд талд						
6	БЗД	16	УДДТ-3	м2	4	Эрүүл мэндийн 10 айл, 8-р цэцэрлэгийн урд						
Дүн			м2	117								
2018 он												
7	СБД	10	УДДТ-36	м2	10	26-р байрны ар талын явган хүний зам	Хэрэгцээний халуун усны буцахын ф80мм 6 у/м шугам хэсэгчлэн сольсон.					
8	БЗД	25	УДДТ-137,138	м2	204	Шинэ монгол сургуулиас 54, 60-р байр луу явсан авто зам	1-р хэлхээний өгөхийн ф200мм 38 у/м шугам шинэчлэн сольсон.					
9	СБД	6	УДДТ-42	м2	14	26-р байрны зүүн талын авто зам	Халаалтын буцах ф100мм шугам солих ажил.					
10	СБД	8	ХҮТ-5	м2	8	1-р байрны 3-р орцны урд талд явган хүний зам	25, 32, 34-р байрны 1-р хэлхээний ф150мм 2 у/м шугам сольсон.					
11	БЗД	25	ХҮТ-4	м2	12	60-р байрны зүүн талын талбай	56-ын 1/2-р байрны 1-р хэлхээний ф125мм шугам нөхсөн.					

12	СБД	10	УДДТ-39	м2	14	86а байрны хойд талын явган хүний зам	1-р хэлхээний ф150мм шугам нөхсөн.
13	БЗД	7	УДДТ-11	м2	20	23-р байрны урд талын авто зам	ХХҮ-ны өгөх ф80мм 1.5 у/м шугам хэсэгчлэн сольсон.
14	СБД	6	УДДТ-40	м2	15	УДД40-р төвийн баруун талд "PC MALL"-ын барилгын хашаанд авто зогсоолд	21-р байрны ххусны ф32-ын шугам сольсон
15	СБД	10	УДДТ-38	м2	16	30-р байрны зүүн хойд талд	13, 30-р байрны гадна бохирын цуглуулгын худгийн ф150 шугам сольсон
16	СБД	6	ХҮТ-5	м2	10	Хүрээ төвийн баруун талын 24а байрны баруун хойд талбай	1-р хэлхээний ф76мм 0.6 у/м шугам сольсон.
17	СБД	10	145	м2	21	УДД145-р төвийн хойд талын авто зам	Цагдаагийн 64-р байрны хху-ны ф80мм-ын шугам сольсон
18	СБД	10	УДДТ-36	м2	20	100 айлын "Атлас"-ын баруун талын талбай	9-р байрны халаалтын буцах ф100мм 4 у/м шугам сольсон.
Дүн				м2	364		
2019 он							
19	СБД	10	ХҮТ-5	м2	73	ХҮТ5-ын харьяа 4а, 46 байрны баруун талд зам сэтэлсэн	1-р хэлхээний ф80мм өгөх шугам 3у/м, буцах шугам 3у/м хэсэгчлэн сольсон.
20	СБД	8	ХҮТ-5	м2	16	Эрхүүгийн 18 байр100айлын сансарлуу явдаг автобусны буудлын урд талын туслах авто зам	1-р хэлхээний өгөх ф/80мм шугам 1у/м сольсон.
21	СБД	10	УДДТ-39	м2	18	19, 20р байрны голын туслах авто зам	Халуун усны өгөх ф150мм шугам 5у/м хэсэгчлэн сольсон
22	БЗД	25	ХҮТ4	м2	29	59р байрны ард талд авто зам, явган хүний зам	Халуун усны өгөх ф150мм шугам 5у/м, буцах ф150мм шугам бу/м хэсэгчлэн сольсон
23	СБД	8	ХҮТ-5	м2	61	100айлаас урагш Эрхүүгийн 18-р байрны ард талын туслах авто зам	1-р хэлхээний өгөх ф/80мм шугам 4у/м сольсон.
24	СБД	6	УДДТ-40	м2	33	УДД40-р төвийн урд 30-р байрны зүүн талд авто зам	Халуун усны өгөх ф50мм шугам 1у/м сольсон
25	БЗД	16	УДДТ-3	м2	18	УДД3-р төвийн харьяа 67, 68-р байрны урд талын туслах зам	ХХҮ-ны өгөх ф80мм шугам 18у/м хэсэгчлэн сольсон
26	БЗД	16	УДД1-р төвийн	4*4М	16	70, 71-р байрны хойд талд авто зогсоол	2-р хэлхээний ф89мм шугам 24у/м хэсэгчлэн сольсон

			харьяа 70, 71-р байр				
27	БЗД	7	УДД10 Занаду майнзын хашаанд	5*6	30	ЗАНАДУ МАЙНЗ ХХК-ны хашаан дотор	2-р хэлхээний ф200мм шугамд цонх гагнасан
28	БЗД	3	УДД21-р төв	5*10м	50	УДД21-р төвийн урд талын машин зогсоол	1-р хэлхээний оруулга ф125мм шугам хэсэгчлэн сольсон
29	БЗД	25	УДД137-р төв	5*75м	375	Шинэ монгол дунд сургуулиас 60-р байрны үзүүр хүртэлх авто зам	1-р хэлхээний ф200мм шугам хэсэгчлэн сольсон
30	СБД	10	ХҮТ5-ын харьяа 16а, б байр	3*30	60	Монгол 3-р Сургуулийн урд талын авто зогсоол	1-р хэлхээний ф100мм шугам хэсэгчлэн сольсон
31	СБД	10	УДД 39-р төв	4*6+4*4	40	19, 20-р байрны голын туслах авто зам	2-р хэлхээний ф150мм шугам хэсэгчлэн сольсон
32	СБД	10	УДД 39-р төв	5*10	50	Ертөнц сургуулиас 30/1-р байрлуу явсан авто зам	2-р хэлхээний ф50мм шугам шинээр татсан.
33	СБД	6	ХҮТ 5-н харьяа Хүрээ төв 24а байр	2*10	20	Сүхбаатар дүүргийн шүүхийн урд талын туслах авто зам	1-р хэлхээний ф200мм шугам хэсэгчлэн сольсон
Дүн				888			

ТӨВ ТҮГЭЭХ ТӨВ							
2018 он							
38	ЧД	4	УДДТ-60	м2	20	Улаанбаатар банкны баруун талд YES реклам чимэглэлтэй байрны урд авто замын зогсоол	Асфальт
34	СБД	1	ХҮТ-8	м2	15	Төв номын сангийн зүүн талд Паркийн 8-р байрны баруун талын авто зам	Асфальт
37	БГД	3	УДДТ-80	м2	14	Хуучин тээврийн товчооны баруун талд Вьетнам засварын гадна авто зам	Асфальт
Дүн				м2	49		
2019 он							

36	СБД	5	УДДТ-63	м2	6	Нарны зам дагуу хуучин тээврийн товчооны зүүн талын 9-н давхар 18.19.20-р байрны голд авто зам шугам.	Асфальт
35	ХУД	1	УДДТ-88	м2	4	19-р хорооллын үйлчилгээний төвийн урд зүгт 18.22-р байрны голд авто зам	Асфальт
39	ЧД	4	УДДТ-45	м2	25	33-р байрны баруун талд орцны үүдэнд 2 хэсэг газар	Асфальт
Дүн				м2	35		
БАРУУН ТҮГЭЭХ ТӨВ							
2017 он							
40	БГД	6	УДДТ-114	м2	16	УДД-114-р төвийн харьяа 21, 22-р байрны хооронд авто зогсоол. /Асфальт/	08-р сарын 10-ны өдөр "0" зогсолтоор шахаад хагарсан. 08-р сарын 14-ний өдөр авто замыг сэтлэж 1-р хэлхээний ф125мм-н 15у/м, 1ш отводын хамт шинэчлэн сольсон.
Дүн				м2	16		
2018 он							
41	БГД	18	УДДТ-103	м2	40	Модны 2-н дунд замын Гранд зочид буудлын хажуу талын 64, 65-р байран дундах автозам /бетон/	ХХУсны өгөхийн ф80мм-н хоолой 3у/м хэсэгчлэн сольсон.
42	БГД	16	УДДТ-114	м2	6	10-р хорооллын 18-р байрнаас 17-р байран дундах авто зам /Асфальт/	Ургал засвараар СХД-н 16-р хороо, 10-р хороолол УДДТ-114-ийн харьяа 18-р байрнаас 17-р байрны оруулга хүртэлх халаалтын ф80мм, хэрэгцээний халуун усны өгөх ф50мм, буцахын ф40мм, хүйтэн усны ф50мм-н 5 хос шугам нийт 120у/м труба шинэчлэн сольсон. /Явган хүний замыг засварласан./
43	БГД	14	УДДТ-121	м2	24	1-р хорооллын 15, 16-р байрны дундах гадна авто зам /Асфальт/	ХХУсны өгөхийн ф80мм-н хоолой 5у/м-г хэсэгчлэн сольсон.
44	БГД	14	УДДТ-121	м2	6	1-р хорооллын 38-р байрны дундах гадна авто зам /Асфальт/	Хүйтэн усны ф50мм-н хоолой 6у/м-г хэсэгчлэн сольсон.

45	СХД	20	УДДТ-130	м2	24	Нефтийн Цээлээ гүний байрны автомашины зогсоол /бетон/	ХХУсны өгөхийн ф50мм-н 2у/м цайран труба хэсэгчлэн сольж усны алдагдал зогсоосон.
Дүн				м2	100		
2019 он							
46	БГД	18	УДДТ-103	м2	4	УДДТөвийн хойд талд хороолол дундах чулуун өрлөгтэй зам	15а-р байр уруу явсан салааны ф80мм-н ган труба 2у/м хэсэгчлэн сольсон.
47	БГД	6	БЧУДДТ-Гаалийн 73, Бат-Эрдэнийн 46-р байр	м2	9	ХҮТ-14-н БЧУДДТ-Гаалийн 73, Бат-Эрдэнийн 46-р байрны 1-р хэлхээ автозам, явган хүний зам /Асфальт/	Ургал засварын төлөвлөгөөнд тусгагдсаны 1-р хэлхээний ф100мм-н ган труба 240у/м-г шинэчлэн сольсон.
48	БГД	18	БЧУДДТ-83а, б-р байр	м2	9	ХҮТ-12-н БЧУДДТ-83а, б-р байрны 1-р хэлхээ автозам /Асфальт/	1-р хэлхээний ф100мм-н ган труба 18у/м-г хэсэгчлэн сольсон.
Дүн				м2	22		
Нийт дүн				м2	1591		

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.

4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гол түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |
| B. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ | |
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.

7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.

9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлзуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ.
Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.
Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ.
Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.
- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг сүутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоноо. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: Авто замын нөхөн сэргээлт засварын ажил
ГЕН 3.1	Төслийн менежер нь : Захиалагч томилно.
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: Гэрээ байгуулсан өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жилийн байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10% байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 14 өдрийн дотор гаргаж өгнө Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200000 төгрөг байна.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож ____ оны ____ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “тэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны _____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1.** Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2.** Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3.** Үнийн санал
- 5.4.** Гэрээний тусгай нөхцөл;
- 5.5.** Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6.** Техникийн тодорхойлолт;
- 5.7.** Зураг;

- 5.8.** Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
5.9. Санхүүжилтийн хуваарь;
5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 6.** Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.
- 7.** Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзольд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 8.** Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
- 9.** Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]